



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 09 сарын 20-одор

Дугаар 13/6

Мандалговь

Орон нутагт тогтвортой суурьшилтай ажиллаж байгаа бүтээлч багш нарыг урамшуулах журам батлах тухай

Монгол Улсын "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай" хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 /а/, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.1.4 дэх заалт, Засаг даргын Зөвлөлийн 13 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. СӨБ болон бага, дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөр, мэргэжилтэй ажилтан сургаж бэлтгэх чадамжид сууринсан сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд бүтээлч санаачилгатай ажиллаж байгаа тэргүүний багш нарын арга туршлагыг аймаг, улсын хэмжээнд сурталчлан таниулах, шилдэг арга туршлагыг түгээн дэлгэрүүлэх, эзэмшиүүлэх, урамшуулах, дэмжих, орон нутагт тогтвортой суурьшилтай ажиллуулах зорилгоор "Орон нутагт тогтвортой суурьшилтай ажиллаж байгаа бүтээлч багш нарыг урамшуулах журам"-ыг хавсралтаар баталсугай.

Хоёр. Журмыг хэрэгжүүлэх ажлыг аймаг, сумын хэмжээнд зохион байгуулан ажиллахыг Боловсрол, соёл урлагийн газар /Ц.Буманзэрэл/, сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

Гурав. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс /А.Нарантуяа/-т үүрэг болгосугай.

Дөрөв. Журмыг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг жил бүрийн төсөвт тусган хэрэгжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс /А.Ганбат/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ

Ж.МӨНХЧУЛУУН

0200892